| 15 | Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал | 62,919 | 65,280 | 66,141 | 68,095 | 74,179 | 82,236 | 76,197 | 85,965 | 83,369 | 90,422 | 75,975 |
| 16 | Боловсрол | 86,269 | 89,819 | 89,552 | 89,091 | 94,989 | 98,876 | 98,738 | 96,108 | 110,735 | 111,299 | 98,964 |

| | | | | | | | | | | | | |
|-------------|---|------------------|------------------|------------------|------------------|------------------|------------------|------------------|------------------|------------------|------------------|------------------|
| 17 | Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа | 37,529 | 40,365 | 37,489 | 38,199 | 40,981 | 39,973 | 49,462 | 44,376 | 60,189 | 47,133 | 49,989 |
| 18 | Урлаг, үзвэр, тоглоом, наадам | 7,357 | 9,248 | 10,602 | 12,333 | 10,090 | 10,104 | 13,835 | 17,999 | 10,812 | 6,350 | 15,155 |
| 19 | Үйлчилгээний бусад үйл ажиллагаа | 19,783 | 20,193 | 20,105 | 20,170 | 19,753 | 22,728 | 23,364 | 24,547 | 29,752 | 24,096 | 28,796 |
| 20 | Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа | 1,318 | 1,458 | 1,406 | 950 | 1,059 | 2,294 | 1,226 | 3,275 | 3,292 | 2,635 | 1,259 |
| 21 | Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа | 3,666 | 2,209 | 1,610 | 1,706 | 1,100 | 1,505 | 2,256 | 2,014 | 2,641 | - | 2,410 |
| Бүгд | | 1,056,441 | 1,103,601 | 1,110,698 | 1,151,223 | 1,147,843 | 1,238,333 | 1,253,023 | 1,146,161 | 1,162,912 | 1,127,111 | 1,128,448 |

ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ НИЙТ АЖЛЫН БАЙРНЫ ЭРЭЛТ НИЙЛҮҮЛЭЛТИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ БОЛОН ИРЭЭДҮЙН ЧИГ ХАНДЛАГА

Тус яамнаас хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн болон бусад шаардлагатай судалгаа, мэдээллийг хийж гүйцэтгэх, судалгааны мэдээллийг иргэд, олон нийтэд тогтмол мэдээлэх бодлого баримтлан ажиллаж байна. Энэ хүрээнд яамны харьяа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтээс **“Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа”⁶**-г жил бүр хийж, нийтэд мэдээлж байгаа бөгөөд энэхүү судалгаа нь хөдөлмөрийн зах зээлийн богино хугацаа буюу дараа жилийн ажиллах хүчний хэрэгцээ, мөн өнгөрсөн жилийн хугацаан дахь ажиллах хүчний хомсдолыг эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажил мэргэжил, байршлаар тодорхойлж, санал зөвлөмж боловсруулдаг.

Судалгааны дүнгээс харахад коронавируст халдвар цар тахлаас шалтгаалсан хүчин зүйлийн нөлөөгөөр эдийн засагт учирч болох хохирлыг тооцоход төвөгтэй, цаашид хэр удаан үргэлжлэх, эдийн засагт ямар хэмжээний хохирол үзүүлэхийг тодорхойлох боломжгүй байгаа ч ажил олгогчид 2022 оныг харьцангуй эерэгээр харж, хүлээлт өндөртэй байна. Улсын хэмжээнд 2022 онд 78.0 мянган ажлын байр бий болох ⁷ ба тэдгээрийн 72.9% хувь нь оны эхний хагаст, үлдсэн 27.1 хувь нь сүүлийн хагаст бий болох төлөвтэй байна.

Ажиллах хүчний нийт эрэлтийн 30.7 хувь нь бөөний болон жижиглэнгийн худалдаа, 14.7 хувь нь барилгын салбарт, 13.1 хувь нь боловсруулах үйлдвэрлэл, 5.2 хувь нь зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбар, 4.8 хувь нь тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбарт бий болно. Ажиллах хүчний эрэлт бүс нутгийн хувьд нэлээд ялгаатай байдаг бөгөөд ихэнх хувь нь Улаанбаатар хотод харьяалагдаж, хангай болон төвийн бүсэд нийт ажиллах хүчний эрэлтийн 20.7 хувь ноогдож байна.

Хөдөлмөрийн зах зээлд шинэ ажлын байрны эрэлт өсөх нь хөдөлмөрийн зах зээл, хөдөлмөр эрхлэлтийн цар хүрээ нэмэгдэх боломж байгааг харуулдаг. Энэ удаад байнгын болон шинэ ажлын байрны эрэлт ажиллах хүчний эрэлтэд өндөр хувийг эзэлж буй нь эерэг хандлага болж байна. Нийт ажиллах хүчний эрэлтийн 84.3 хувь нь байнгын, 15.7 хувь нь түр ажиллах хүчний эрэлт, 69.8 хувь нь шинэ, 30.2 хувь нь сул ажлын байрны эрэлт байна. Харин сүүлийн 12 сарын шинэ ажиллагчдын хүрээнд дэх ажлын байрны 57.7 хувь, нээлттэй ажлын байрны 51.4 хувийг сул ажлын байр эзэлж байна. Энэ нь ажиллагчдын салбарын дотоод болон салбар хоорондын шилжилт хөдөлгөөн их буюу хөдөлмөр эрхлэлт тогтворгүй байх үзэгдэл өмнөх жилүүдийн адил байсаар байгааг илтгэж байна.

Ажиллагчдын шилжилт хөдөлгөөн 30-аас доош ажиллагчидтай жижиг болон дунд аж ахуйн нэгжүүдэд зонхилж, улмаар хөдөлмөр эрхлэлтийн тогтвортой бус байдлыг үүсгэж байна. Ажил олгогчид ажил хайгчийн мэргэжлийн нарийн ур чадвар гэхээс илүүтэй хувь хүний зөөлөн ур чадварыг хамгийн чухал үзүүлэлт гэж үздэг хандлага хэвээр төдийгүй бие даан ажиллах чадвар, найдвартай, хариуцлагатай байдал, эерэг зөв хандлагатай байдал,

⁶ <http://rilsp.gov.mn>

⁷ Өмнөх оны судалгааны дүнтэй харьцуулахад 25.0 гаруй мянган ажлын байр буюу 48.3 хувиар өссөн.

харилцааны ур чадвар, цаг ашиглах чадварыг хамгийн ихээр чухалчилж үзжээ. Эдгээр зан чанарын зөв төлөвшил бүхий ажил горилогчид мэргэжлийн ур чадварыг дадлага болон төрөл бүрийн сургалт, арга хэмжээгээр эзэмшүүлэх боломжтой гэж үзсэн хэвээр байна. Харин мэргэжлийн ур чадварын хувьд төдийлөн өндөр шаардлага тавихгүй ч, ажлын байрны аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн мэдлэг, ажлын ёс зүйтэй байх, шинэ санаа гаргах чадварыг илүүд үзэж, боловсролын түвшний тухайд тодорхой хэмжээний боловсрол эзэмшсэн байх шаардлагыг түлхүү дурьдсан байна.

Өнгөрсөн онд аж ахуйн нэгж байгууллагуудад нийт 36.9 мянган ажиллах хүчний хомсдол бий болжээ. Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар үзвэл бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклын засвар үйлчилгээ, боловсруулах үйлдвэрлэл, барилгын салбаруудад хамгийн их хомсдол үүссэн ба ажиллах хүчний нийт хомсдолын 61.4 хувь нь ногдож байна.

Ажил мэргэжлээрх ажиллах хүчний эрэлт болон ажиллах хүчний хомсдолын мэдээлэл бусад ажил мэргэжлээр тооцдог үр дүнгүүдээс харахад хэд хэдэн төрлийн ажил мэргэжлийн ажиллах хүчин аль ч үзүүлэлтэд байнга нэрлэгдэж, энэ үр дүн сүүлийн жилүүдэд давтагдаж байгаа нь онцгойлон анхаарал татаж байна. Өөрөөр хэлбэл тодорхой хэдэн ажил мэргэжил болох тогооч, зөөгч, жолооч, гагнуурчин, барилгын болон бусад туслах ажилтан, цэвэрлэгч зэрэг мэргэжлийн хүрээн дэх хөдөлмөр эрхлэлтийн тогтворгүй байдал нь хөдөлмөрийн зах зээлд нөлөөлөхүйц өөрчлөлтийг харуулсаар байна.

Түүнчлэн Монгол Улсын хүн амын тоо тогтмол өсөлттэй байгаа хэдий ч хөдөлмөрийн насны хүн ам сүүлийн жилүүдэд буурах хандлагатай байна. Хөдөлмөрийн насны хүн ам 2021 оны IV улирлын байдлаар 2104.6 мянга байгаа нь цар тахлын өмнөх үе буюу 2020 оны мөн үетэй харьцуулахад 1.4 хувиар буурсан байна. Тэдгээрийн 58 хувийг ажиллах хүч, 42 хувийг ажиллах хүчнээс гадуурх хүн ам эзэлж байна. Хөдөлмөрийн насны хүн амд ажиллах хүчний эзлэх хувь 2019 оноос 2.7 пунктээр буурсан. Ажиллах хүч 2018 оноос тасралтгүй буурсан үзүүлэлттэй байна. (Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа-2021) номыг хавсаргав.

Хүснэгт 1. Хөдөлмөрийн эрэлт⁸, ЭЗҮА-ны салбараар, 2023-2024* он

| 2023 | <i>M1</i> | <i>M2</i> | <i>M3</i> | <i>M4</i> | <i>M5</i> | <i>M6</i> | <i>M7</i> | <i>M8</i> | <i>M9</i> | <i>M10</i> | <i>Нийт</i> |
|-------------|-----------|-----------|-----------|-----------|-----------|-----------|-----------|-----------|-----------|------------|-------------|
| <i>A</i> | 41 | 31 | 15 | 8 | 11 | 11,192 | 2,548 | 40 | 75 | - | 13,962 |
| <i>B</i> | 323 | 702 | 199 | 90 | 183 | 3 | 399 | 1,698 | 520 | - | 4,116 |
| <i>C</i> | 476 | 555 | 197 | 146 | 312 | 74 | 3,306 | 525 | 472 | - | 6,063 |
| <i>D</i> | 57 | 239 | 118 | 27 | 173 | - | 276 | 125 | 277 | - | 1,291 |
| <i>E</i> | 47 | 75 | 52 | 33 | 56 | - | 118 | 124 | 459 | - | 965 |
| <i>F</i> | 378 | 726 | 81 | 89 | 114 | - | 2,469 | 391 | 729 | - | 4,977 |
| <i>G</i> | 1,591 | 1,305 | 106 | 151 | 8,563 | 23 | 1,087 | 441 | 1,003 | - | 14,270 |
| <i>H</i> | 130 | 232 | 77 | 221 | 222 | - | 109 | 3,325 | 195 | - | 4,511 |
| <i>I</i> | 334 | 47 | 2 | 67 | 1,029 | - | 8 | 8 | 310 | - | 1,804 |

⁸ Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгааны 2012-2022 оны тоон мэдээлэлд үндэслэн боловсруулав.

| | | | | | | | | | | | |
|-------------|-------|--------|-------|-------|--------|--------|--------|-------|-------|-----|--------|
| <i>J</i> | 85 | 444 | 39 | 109 | 20 | - | 34 | 26 | 28 | - | 787 |
| <i>K</i> | 130 | 319 | 78 | 280 | 21 | - | 3 | 39 | 69 | - | 939 |
| <i>L</i> | 18 | 26 | 3 | - | - | - | - | - | 16 | - | 62 |
| <i>M</i> | 182 | 657 | 149 | 34 | 11 | - | 18 | 25 | 23 | - | 1,099 |
| <i>N</i> | 225 | 198 | 33 | 41 | 171 | 4 | 29 | 73 | 126 | - | 900 |
| <i>O</i> | 679 | 1,418 | 623 | 674 | 453 | 15 | 136 | 269 | 687 | 535 | 5,489 |
| <i>P</i> | 334 | 3,460 | 91 | 172 | 735 | 7 | 104 | 52 | 947 | - | 5,901 |
| <i>Q</i> | 68 | 1,728 | 279 | 58 | 244 | - | 31 | 57 | 270 | - | 2,734 |
| <i>R</i> | 135 | 444 | 112 | 40 | 80 | 2 | 30 | 20 | 190 | - | 1,052 |
| <i>S</i> | 149 | 211 | 91 | 47 | 748 | - | 22 | 40 | 172 | - | 1,481 |
| <i>Huũm</i> | 5,383 | 12,817 | 2,347 | 2,284 | 13,146 | 11,321 | 10,726 | 7,276 | 6,568 | 535 | 72,403 |

| 2024 | <i>M1</i> | <i>M2</i> | <i>M3</i> | <i>M4</i> | <i>M5</i> | <i>M6</i> | <i>M7</i> | <i>M8</i> | <i>M9</i> | <i>M10</i> | <i>Huũm</i> |
|-------------|-----------|-----------|-----------|-----------|-----------|-----------|-----------|-----------|-----------|------------|-------------|
| <i>A</i> | 42 | 34 | 12 | 8 | 11 | 12,263 | 1,403 | 43 | 82 | - | 13,898 |
| <i>B</i> | 292 | 649 | 158 | 78 | 161 | 3 | 334 | 1,528 | 457 | - | 3,660 |
| <i>C</i> | 446 | 534 | 168 | 144 | 317 | 72 | 3,209 | 505 | 451 | - | 5,845 |
| <i>D</i> | 58 | 253 | 107 | 25 | 197 | - | 280 | 121 | 296 | - | 1,338 |
| <i>E</i> | 53 | 65 | 52 | 27 | 37 | - | 99 | 124 | 424 | - | 881 |
| <i>F</i> | 406 | 771 | 65 | 91 | 111 | - | 2,416 | 399 | 747 | - | 5,006 |
| <i>G</i> | 2,019 | 1,621 | 139 | 167 | 8,157 | 22 | 1,336 | 620 | 1,120 | - | 15,200 |
| <i>H</i> | 131 | 259 | 80 | 240 | 245 | - | 92 | 3,494 | 174 | - | 4,715 |
| <i>I</i> | 312 | 44 | 1 | 64 | 932 | - | 6 | 6 | 288 | - | 1,652 |
| <i>J</i> | 75 | 420 | 34 | 101 | 18 | - | 29 | 19 | 26 | - | 723 |
| <i>K</i> | 124 | 283 | 59 | 258 | 19 | - | - | 36 | 63 | - | 843 |
| <i>L</i> | 20 | 26 | 2 | - | - | - | - | - | 15 | - | 63 |
| <i>M</i> | 189 | 673 | 146 | 41 | 8 | - | 16 | 24 | 22 | - | 1,117 |
| <i>N</i> | 242 | 208 | 39 | 47 | 171 | 5 | 30 | 77 | 121 | - | 940 |
| <i>O</i> | 679 | 1,445 | 621 | 696 | 441 | 16 | 139 | 268 | 717 | 553 | 5,575 |
| <i>P</i> | 343 | 3,459 | 48 | 172 | 741 | 4 | 108 | 40 | 950 | - | 5,865 |
| <i>Q</i> | 70 | 1,683 | 219 | 60 | 235 | - | 28 | 52 | 274 | - | 2,621 |
| <i>R</i> | 153 | 464 | 119 | 39 | 84 | 6 | 24 | 14 | 187 | - | 1,091 |
| <i>S</i> | 138 | 209 | 94 | 46 | 732 | - | - | 43 | 161 | - | 1,422 |
| <i>Huũm</i> | 5,793 | 13,099 | 2,163 | 2,303 | 12,615 | 12,391 | 9,549 | 7,412 | 6,575 | 553 | 72,454 |

| Салбар | Тодорхойлолт |
|-----------------|---|
| A | Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур |
| B | Уул уурхай, олборлолт |
| C | Боловсруулах үйлдвэрлэл |
| D | Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж |
| E | Ус хангамж; сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа |
| F | Барилга |
| G | Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ |
| H | Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа |
| I | Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ |
| J | Мэдээлэл, холбоо |
| K | Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа |
| L | Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа |
| M | Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа |
| N | Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа |
| O | Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал |
| P | Боловсрол |
| Q | Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа |
| R | Урлаг, үзвэр, тоглоом, наадам |
| S | Үйлчилгээний бусад үйл ажиллагаа |
| Мэргэжил | Тодорхойлолт |
| M1 | Менежер |
| M2 | Мэргэжилтэн |
| M3 | Техникч болон туслах/ дэд мэргэжилтэн |
| M4 | Контор, үйлчилгээний ажилтан |
| M5 | Худалдаа, үйлчилгээний ажилтан |
| M6 | Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан |
| M7 | Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажил |
| M8 | Машин механизм, төхөөрөмжийн операторч, угсрагч |
| M9 | Энгийн ажил, мэргэжил |
| M10 | Зэвсэгт хүчний ажил, мэргэжил |

Олон улсад хөдөлмөрийн зах зээлийн ажлын байрны эрэлтийн чиг хандлага ирээдүйд хэрхэн өөрчлөгдөхийг **Дэлхийн эдийн засгийн форум**аас гаргасан **“Ирээдүйн ажлын байр”** тайланд ирээдүйд үнэ цэнэ нь өсөх, буурах мэргэжлүүд болон ур чадварын ирээдүйн чиг хандлагыг тодорхойлсон бөгөөд өгөгдөлтэй ажиллах болон хиймэл оюун ухааны чиглэлийн мэргэжилтэн хамгийн их эрэлттэй байх бол нөгөө талд мэдээллийн сангийн ажилтан, нарийн бичиг, нягтлан бодох бүртгэл зэрэг мэргэжлүүдийн эрэлт буурах хандлагатай байна.

| Эрэлт хамгийн НЭМЭГДСЭН ажлын байр | Эрэлт хамгийн БУУРСАН ажлын байр |
|--|--|
| 1. Өгөгдлийн шинжээч, эрдэмтэд | 1. Өгөгдлийн бүртгэлийн ажилтан |
| 2. Хиймэл оюун ухаан /AI/ ба машин сургалтын мэргэжилтнүүд | 2. Захиргааны болон гүйцэтгэх нарийн бичгийн дарга нар |
| 3. Том мэдээллийн мэргэжилтнүүд | 3. Нягтлан бодох бүртгэл, нягтлан бодох бүртгэл, цалингийн ажилтан |
| 4. Дижитал маркетинг ба стратегийн мэргэжилтнүүд | 4. Нягтлан бодогчид ба аудиторрууд |
| 5. Процессийн автоматжуулалтын мэргэжилтнүүд | 5. Угсрах, үйлдвэрийн ажилчид |
| 6. Бизнес хөгжүүлэх мэргэжилтнүүд | 6. Бизнесийн үйлчилгээ ба захиргааны менежерүүд |
| 7. Дижитал өөрчлөлтийн мэргэжилтнүүд | 7. Үйлчлүүлэгчийн мэдээлэл ба үйлчлүүлэгчдэд үйлчлэх ажилчид |
| 8. Мэдээллийн аюулгүй байдлын шинжээчид | 8. Ерөнхий ба үйл ажиллагааны менежерүүд |
| 9. Програм хангамж ба програм хөгжүүлэгчид | 9. Механик ба машин засварчид |
| 10. Интернетийн зүйлийн мэргэжилтнүүд | 10. Материал-Бүртгэл, Хадгаламж хөтлөгч |
| 11. Төслийн менежерүүд | 11. Санхүүгийн шинжээчид |
| 12. Бизнесийн үйлчилгээ ба захиргааны менежерүүд | 12. Шуудангийн үйлчилгээний ажилтан |
| 13. Мэдээллийн сан ба сүлжээний мэргэжилтнүүд | 13. Борлуулалтын төлөөлөгч, бөөний ба үйлдвэрлэгч, техник ба шинжлэх ухааны бүтээгдэхүүн |
| 14. Роботын инженерүүд | 14. Харилцааны менежерүүд |
| 15. Стратегийн зөвлөхүүд | 15. Банкны теллер, холбогдох бичиг хэргийн ажилтан |


**АЖИЛ ХАЙГЧ, БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭН, АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, АЖИЛД
ЗУУЧЛАГДСАН БОЛОН, ШИНЭ АЖЛЫН БАЙРНЫ ТАЛААРХ ТООН МЭДЭЭ**
/2022 оны 4 сарын байдлаар, бүсээр, аймаг, дүүрэг, хүйсээр/

| | | Ажил хайгч ⁹ | | Бүртгэлтэй ажилгүй иргэн | | Ажлын байрны захиалга | Нийт зуучлагдсан | | ШАБ | |
|-----------|--------------------|-------------------------|----------------|--------------------------|----------------|-----------------------|------------------|----------------|-------------|----------------|
| | | Нийт дүн | Үүнээс эмэгтэй | Нийт дүн | Үүнээс эмэгтэй | | Нийт дүн | Үүнээс эмэгтэй | Нийт дүн | Үүнээс эмэгтэй |
| 1 | Баруун бүс | 5301 | 2502 | 3227 | 1500 | 662 | 616 | 287 | 368 | 196 |
| 2 | Баян-Өлгий | 393 | 137 | 371 | 132 | 48 | 56 | 10 | 75 | 20 |
| 3 | Говь-Алтай | 844 | 382 | 627 | 288 | 16 | 20 | 9 | 10 | 4 |
| 4 | Завхан | 1189 | 540 | 832 | 383 | 60 | 49 | 23 | 42 | 25 |
| 5 | Увс | 1172 | 563 | 809 | 393 | 254 | 238 | 163 | 211 | 128 |
| 6 | Ховд | 1703 | 880 | 588 | 304 | 284 | 253 | 82 | 30 | 19 |
| 7 | Хангайн бүс | 6045 | 3198 | 4069 | 2190 | 1321 | 901 | 487 | 890 | 481 |
| 8 | Архангай | 1243 | 599 | 689 | 330 | 176 | 204 | 91 | 95 | 41 |
| 9 | Баянхонгор | 1104 | 590 | 1009 | 549 | 286 | 166 | 76 | 263 | 136 |
| 10 | Булган | 474 | 231 | 261 | 136 | 128 | 60 | 38 | 125 | 57 |
| 11 | Орхон | 2023 | 1136 | 1403 | 784 | 602 | 321 | 207 | 275 | 187 |
| 12 | Өвөрхангай | 953 | 517 | 523 | 299 | 90 | 108 | 58 | 74 | 34 |
| 13 | Хөвсгөл | 248 | 125 | 184 | 92 | 39 | 42 | 17 | 58 | 26 |
| 14 | Төвийн бүс | 4510 | 2107 | 2816 | 1314 | 2212 | 1469 | 651 | 924 | 414 |
| 15 | Говьсүмбэр | 356 | 193 | 174 | 87 | 125 | 91 | 43 | 38 | 23 |
| 16 | Дархан-Уул | 1401 | 667 | 909 | 440 | 574 | 395 | 176 | 473 | 203 |
| 17 | Дорноговь | 286 | 121 | 197 | 84 | 202 | 137 | 50 | 41 | 11 |
| 18 | Дундговь | 311 | 141 | 208 | 97 | 95 | 74 | 43 | 8 | 2 |
| 19 | Өмнөговь | 377 | 168 | 126 | 63 | 414 | 276 | 128 | 172 | 75 |
| 20 | Сэлэнгэ | 851 | 370 | 686 | 295 | 437 | 310 | 133 | 136 | 67 |
| 21 | Төв | 928 | 447 | 516 | 248 | 365 | 186 | 78 | 56 | 33 |
| 22 | Зүүн бүс | 2071 | 884 | 1603 | 691 | 558 | 442 | 199 | 220 | 69 |
| 23 | Дорнод | 1216 | 509 | 916 | 394 | 250 | 223 | 74 | 187 | 59 |
| 24 | Сүхбаатар | 595 | 234 | 461 | 175 | 132 | 65 | 32 | 13 | 5 |
| 25 | Хэнтий | 260 | 141 | 226 | 122 | 176 | 154 | 93 | 20 | 5 |
| 26 | Улаанбаатар | 6451 | 3227 | 4589 | 2379 | 7615 | 1932 | 1009 | 1533 | 879 |
| 27 | Хан-Уул | 926 | 495 | 801 | 437 | 1627 | 262 | 138 | 162 | 61 |
| 28 | Багануур | 371 | 192 | 331 | 173 | 157 | 66 | 40 | 10 | 7 |
| 29 | Баянзүрх | 1119 | 549 | 924 | 462 | 2027 | 369 | 174 | 312 | 226 |
| 30 | Налайх | 163 | 84 | 106 | 56 | 138 | 69 | 35 | 17 | 8 |
| 31 | Баянгол | 1038 | 526 | 876 | 442 | 1067 | 235 | 142 | 217 | 124 |
| 32 | Сүхбаатар | 422 | 215 | 367 | 185 | 1191 | 150 | 62 | 368 | 209 |
| 33 | Чингэлтэй | 1032 | 536 | 763 | 414 | 665 | 137 | 66 | 50 | 35 |
| 34 | Багахангай | 205 | 106 | 96 | 56 | 48 | 40 | 19 | 10 | 5 |
| 35 | Сонгинохайрхан | 1175 | 524 | 325 | 154 | 695 | 604 | 333 | 387 | 204 |
| 36 | УЛСЫН ДҮН | 24378 | 11918 | 16304 | 8074 | 12368 | 5360 | 2633 | 3935 | 2039 |


Эх сурвалж: ХХҮЕГ

⁹ 2022 оны 04 сарын байдлаар аймаг, дүүргүүдийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүдэд ажил идэвхтэй хайж буй ажил хайгч иргэдийн тоо **24378** болж өмнөх сараас **123** хүнээр буюу **0,5** пунктээр өссөн ба өмнөх оны мөн үеэс **902** хүнээр буюу **3,5** пунктээр буурсан байна.


Ажил хайгч иргэд: насаар, хүйсээр: Ажил хайгч иргэдийг насны бүлгээр авч үзвэл 13.2 хувь буюу 3221 нь 15-24 насны, 35,9 хувь буюу 8758 нь 25-34 насны, 28,9 хувь буюу 7035 нь 35-44 насны, 17,6 хувь буюу 4301 нь 45-54 насны, 3,3 хувь буюу 812 нь 55-59 насны, 1,0 хувь буюу 251 нь 60-аас дээш насныхан эзэлж байна.



Ажил хайгч иргэд: боловсролоор: Нийт ажил хайгч иргэдийн 217 буюу 0,9 хувь нь магистр, доктор, 6242 буюу 25,6 хувь нь дипломын болон бакалаврын, 1185 буюу 4,9 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 1755 буюу 7,2 хувь нь техникийн болон мэргэжлийн, 12716 буюу 52,2 хувь нь бүрэн дунд, 1436 буюу 5,9 хувь нь суурь, 497 буюу 2,1 хувь нь бага, 305 буюу 1,3 хувь нь боловсролгүй иргэд эзэлж байна.




Бүртгэлтэй ажилгүй иргэд: 2022 оны 04 сарын байдлаар аймаг, дүүргүүдийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүдэд бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо **16304** болж өмнөх сараас 318 хүнээр буюу 1,9 пунктээр буурсан ба өмнөх оны мөн үетэй харьцуулан авч үзвэл: өмнөх оны мөн үеэс 385 хүнээр буюу 2,3 пунктээр буурсан байна.




Бүртгэлтэй ажилгүй иргэд бүсээр байршилаар: Нийт бүртгэлтэй ажилгүй иргэдийн 3227 буюу 19,8 хувь нь Баруун бүсэд, 4069 буюу 25,0 хувь нь Хангайн бүсэд, 2816 буюу 17,3 хувь нь Төвийн бүсэд, 1603 буюу 9,8 хувь нь Зүүн бүсэд, 4589 буюу 28,1 хувь нь Улаанбаатарт байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэд: насаар, хүйсээр




Бүртгэлтэй ажилгүй иргэдийг насны бүлгээр авч үзвэл 1,5 хувь буюу 2359 нь 15-24 насны, 36,9 хувь буюу 6017 нь 25-34 насны, 27,9 хувь буюу 4556 нь 35-44 насны, 16,4 хувь буюу 2677 нь 45-54 насны, 3,2 хувь буюу 515 нь 55-59 насны, 1,1 хувь буюу 180 нь 60-аас дээш насныхан эзэлж байна.



Бүртгэлтэй ажилгүй иргэд: боловсролоор: Нийт бүртгэлтэй ажилгүй иргэдийн 148 буюу 0,9 хувь нь магистр, доктор, 4607 буюу 28,3 хувь нь дипломын болон бакалаврын, 780 буюу 4,8 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 1254 буюу 7,7 хувь нь техникийн болон мэргэжлийн, 8086 буюу 49,5 хувь нь бүрэн дунд, 914 буюу 5,6 хувь нь суурь, 318 буюу 2,0 хувь нь бага, 197 буюу 1,2 хувь нь боловсролгүй иргэд эзэлж байна.

Нийт бүртгэлтэй ажилгүй иргэдийн 8074 буюу 49,4 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээ: Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээ үзүүлсэн байдлыг 2022 оны 04 сарын байдлаар авч үзвэл:

- Зорилтот бүлгээр ганцаарчилсан хэлбэрээр зөвлөгөө, мэдээлэл авсан 6924 нийт иргэн, үүнээс эмэгтэй 3723 байна.
- Зорилтот бүлгээр бүлгийн сургалт, зөвлөгөөний хэлбэрээр ажил, үйлчилгээнд хамрагдсан 4944 иргэн, үүнээс эмэгтэй 2398 байна.
- Дээрх үйлчилгээнд хамрагдаж үйлчилгээ авсан байгууллагын тоо 122, үйлчилгээ авсан нийт иргэд 11868 үүнээс эмэгтэй 6121 байна.



Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох,мэдээллээр хангах үйлчилгээний ганцаарчилсан зөвлөгөө авсан байдлыг байршилаар харуулвал:

| № | Аймаг, дүүрэг, байгууллагаар | Ганцаарчилсан зөвлөгөө авсан хүний тоо | Үүнээс эмэгтэй |
|----|------------------------------|--|----------------|
| | Баруун бүс-Дүн | 721 | 357 |
| 1 | Баян-Өлгий | 139 | 39 |
| 2 | Говь-Алтай | 93 | 54 |
| 3 | Завхан | 93 | 46 |
| 4 | Увс | 170 | 101 |
| 5 | Ховд | 226 | 117 |
| | Хангайн бүс-Дүн | 837 | 490 |
| 6 | Архангай | 94 | 57 |
| 7 | Баянхонгор | 85 | 51 |
| 8 | Булган | 102 | 67 |
| 9 | Орхон | 182 | 101 |
| 10 | Хөвсгөл | 168 | 117 |
| 11 | Өвөрхангай | 206 | 97 |
| | Төвийн бүс-Дүн | 1014 | 477 |
| 12 | Говьсүмбэр | 52 | 33 |
| 13 | Дархан-Уул | 241 | 84 |
| 14 | Дорноговь | 122 | 60 |
| 15 | Дундговь | 130 | 77 |
| 16 | Сэлэнгэ | 163 | 74 |
| 17 | Төв | 127 | 66 |
| 18 | Өмнөговь | 179 | 83 |
| | Зүүн бүс-Дүн | 595 | 311 |
| 19 | Дорнод | 88 | 30 |
| 20 | Сүхбаатар | 88 | 46 |
| 21 | Хэнтий | 419 | 235 |
| | Улаанбаатар | 3757 | 2088 |
| 22 | Багануур | 84 | 48 |
| 23 | Багахангай | 36 | 21 |
| 24 | Баянгол | 642 | 369 |
| 25 | Баянзүрх | 807 | 442 |
| 26 | Налайх | 251 | 181 |
| 27 | Сонгинохайрхан | 1095 | 602 |
| 28 | Сүхбаатар | 287 | 140 |
| 29 | Хан-Уул | 230 | 111 |
| 30 | Чингэлтэй | 325 | 174 |
| | УЛСЫН ДҮН | 6924 | 3723 |

Ажил олгогчдоос ирүүлсэн ажлын байрны захиалга: Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагуудын үйл ажиллагааны хүрээнд хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг ажил олгогчдоос ирүүлж буй ажлын сул байрны захиалгаар, нийлүүлэлтийг ажиллахад бэлэн ажил идэвхтэй хайж буй бүртгэлтэй ажилгүй иргэдээр тооцож байгаа ба ажлын байрны хомсдолоос шалтгаалан эрэлт, нийлүүлэлтийн харьцаа харилцан адилгүй байна.

Ажил олгогчдоос ирүүлсэн ажлын байрны захиалгын ашиглалт аймаг нийслэлд ялгаатай байна. Тухайлбал аймгийн дунджаар 38.4 хувьтай байхад нийслэлд 61.6 хувьтай байна. Улсын хэмжээнд ажлын байрны ашиглалт 43,3 хувьтай байна.

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг сүүлийн 3 жилээр харуулвал:



2022 оны 04 сард ажил олгогчдоос нийт 12368 ажлын байрны захиалга ирүүлсэн байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад тайлант хугацаанд ажил олгогчдоос ирүүлсэн ажлын байрны захиалга 3361 буюу 27,1 хувиар өссөн байна.

Ажлын байрны захиалгыг эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар 2022 оны 04-р сарын байдлаар авч үзвэл дараах байдалтай байна.


| № | Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал | Ажлын байрны захиалгын тоо | Эзлэх хувь %/ |
|---|--|----------------------------|---------------|
| 1 | Хөдөө аж ахуй, загас барилт, ан агнуур | 307 | 2.5 |
| 2 | Уул уурхай олборлолт | 2292 | 18.5 |
| 3 | Боловсруулах үйлдвэр | 702 | 5.7 |
| 4 | Цахилгаан, хий, уур агааржуулалт | 82 | 0.7 |
| 5 | Усны хангамж бохир ус зайлуулах систем хог хаягдал | 183 | 1.5 |

| | | | |
|------------|--|--------------|------------|
| 6 | Барилга | 1146 | 9.3 |
| 7 | Бөөний ба жижиглэнгийн худалдаа үйлчилгээ | 724 | 5.9 |
| 8 | Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа | 64 | 0.5 |
| 9 | Зочид буудал, зоогийн газар | 298 | 2.4 |
| 10 | Мэдээлэл холбоо | 33 | 0.3 |
| 11 | Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа | 137 | 1.1 |
| 12 | Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа | 52 | 0.4 |
| 13 | Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа | 6 | 0 |
| 14 | Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа | 373 | 3 |
| 15 | Төрийн удирдлага болон батлан хамгаалах үйл ажиллагаа | 522 | 4.2 |
| 16 | Боловсрол | 743 | 6 |
| 17 | Эрүүл мэнд, нийгмийн халамж | 434 | 3.5 |
| 18 | Урлаг үзвэр тоглоом наадам | 138 | 1.1 |
| 19 | Үйлчилгээний бусад үйл ажиллагаа | 4043 | 32.7 |
| 20 | Хүн хөлслөн ажиллуулдаг, өрхийн аж ахуй | 55 | 0.4 |
| 21 | Олон улсын байгууллага суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа | 34 | 0.27 |
| Дүн | | 12368 | 100 |


Ажлын байрны захиалгыг ажил мэргэжлийн ангиллаар авч үзвэл дараах байдалтай байна.

| № | Ажил мэргэжлийн ангилал | Ажил олгогчдоос ирүүлсэн ажлын байрны захиалгын тоо | Эзлэх хувь %/ |
|------------|--|---|---------------|
| 1 | Менежер | 534 | 4.3 |
| 2 | Мэргэжилтэн | 2141 | 17.3 |
| 3 | Техникч болон туслах /дэд мэргэжилтэн/ | 1278 | 10.3 |
| 4 | Контор үйлчилгээний ажилтан | 753 | 6.1 |
| 5 | Худалдаа үйлчилгээний ажилтан | 2139 | 17.3 |
| 6 | ХАА, загас ан агнуурын ажилтан | 118 | 1 |
| 7 | Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан | 2396 | 19.4 |
| 8 | Суурин төхөөрөг, машин механизмын операторч, угсрагч | 1136 | 9.2 |
| 9 | Энгийн ажил, мэргэжил | 1770 | 14.3 |
| 10 | Зэвсэгт хүчний ажил, мэргэжил | 103 | 0.8 |
| Дүн | | 12368 | 100 |

Ажилд зуучлах үйлчилгээ: 2022 оны 04 сарын байдлаар ажил олгогчдоос нийт 12368 ажлын байрны захиалга ирүүлсэнээс 5360 иргэнийг эдгээр ажлын байранд ажилд зуучлан оруулсан байна. Энэ нь ажлын байрны ашиглалт 43,3 хувьтай байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад ажилд зуучлан оруулсан хүний тоо 1177 хүнээр буюу 21,9 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.




Нийт ажилд зуучлагдан орсон иргэдийг ажил мэргэжлийн ангиллаар авч үзвэл:



Нийт ажилд зуучлагдан орсон иргэдийг насны бүлгээр авч үзвэл:

| Насны бүлэг | Ажилд зуучлагдан орсон иргэдийн тоо | Үүнээс эмэгтэй | Эзлэх хувь |
|-------------|-------------------------------------|----------------|------------|
| 15-24 | 1072 | 474 | 20 |
| 25-34 | 1836 | 947 | 34.3 |
| 35-44 | 1384 | 721 | 25.8 |
| 45-54 | 813 | 386 | 15.2 |
| 55-59 | 179 | 77 | 3.3 |
| 60+ | 76 | 28 | 1.4 |
| ДҮН | 5360 | 2633 | 100 |



Нийт ажилд зуучлагдан орсон иргэдийг өмчийн хэлбэрээр авч үзвэл:

| Байгууллагын өмчийн хэлбэрээр | Ажилд орсон иргэдийн тоо: Бүгд | Үүнээс: Эмэгтэй | Эзлэх хувь |
|-------------------------------|--------------------------------|-----------------|------------|
| Төрийн өмчийн | 1659 | 1068 | 31.0 |
| Орон нутгийн өмчийн | 139 | 49 | 2.6 |
| Хувийн өмчийн | 3562 | 1516 | 66.5 |
| ДҮН | 5360 | 2633 | 100 |



Ажлын шинэ байр: Улсын хэмжээнд 2022 оны 04 сард нийт 3935 ажлын шинэ байр бий болж, түүнд ажилгүй иргэдийг бүрэн байршуулсан байна.

Ажлын шинэ байрны бүртгэлийг орон нутгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүдийн ажлын байрны бүртгэл хариуцсан мэргэжилтнүүд Ажил олгогч байгууллагууд болон аж ахуйн нэгжтэй холбогдон хамтран бүртгэх ажлыг хийж гүйцэтгэж байна. Тухайн нутаг дэвсгэр дээрх шинээр байгуулагдсан салбар нэгжүүд буюу шинээр бий болж байгаа ажлын байрыг бүртгэж мэдээллийг “LMIS” програмаар нэгтгэн гаргаж байна. Тайлант хугацаанд нийт 3935 ажлын шинэ байрыг бүртгэж тухайн ажлын байранд ажилд орсон иргэдийн мэдээллээр баталгаажуулсан байна. Ажлын шинэ байранд ажилд орсон иргэдийг

өмнөх оны мөн үетэй харьцуулан авч үзвэл 1241 хүнээр буюу 31,5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.



Нийт шинэ ажлын байрнаас, байнгын шинэ ажлын байр 3421 буюу 92,7 хувь, улирлын шинэ ажлын байр 190 буюу 3.2 хувь, түр шинэ ажлын байр 324 буюу 4.1 хувийг тус тус эзэлж байна .